



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/1/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал
бөгөөд

тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469

Цахим хаяг:

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079

Цахим хаяг:

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК
Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/190
танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
О.ОДОНЧИМЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 17,410.0 мянган төгрөгийн зөрчил, данс бүртгэлд малын үнийг зах зээлийн үнээс хэт доогуур үнээр үнэлж бүртгэсэн 294.2 мянган төгрөгийн зөрчил нь тус тус санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал О.Одончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар “Уваа-уул аудит” ХХК –ийн захирал Ч.Мөнхтуяа, чанар хяналтын менежер А.Оюун, аудитор Ц.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймаг дахь Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Хүн бүр эх хэлний чадвараа дээшлүүлэн өөрийгөө өөрийнхөө хөгжил төлөвшилд ахиц гаргах”-ад оршино.

Дорноговь аймаг дахь Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суурь боловсрол эзэмшүүлэх,
- Насан туршийн боловсролын үйлчилгээг явуулж иргэдийн насан туршдаа хөгжих боломжийг бүрдүүлнэ гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

“Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагаж гарсан эрх зүйн актууд 2019 оноос эхлэн үйлчилж байна. Тухайлбал:

- Журам батлах тухай (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох) Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох) Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Нөхөх төлбөр олгох) Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох) Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол
- Журам батлах тухай (төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох) Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол
- Түрээсийн сурах бичиг ашиглуулах талаарх БСШУСС-ын 2019 оны А/302 дугаар тушаал
- Нийгмийн даатгалын тухай хуульд 2017 онд орсон өөрчлөлтийн дагуу шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт зэрэг болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous-3” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд эрсдэлтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувийг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” гэж үзсэнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,750.8 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шат болон нийт зардлын дүнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,063.9 мянган төгрөгөөр буюу 0,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	2,095.1	2,095.1
Авлага	309.8	1,500.0	1,190.2
Урьдчилгаа	0.0		0.0
Бараа материал	114,772.1	138,651.3	23,879.1
Үндсэн хөрөнгө	2,738,576.8	2,719,476.2	-19,100.6
Нийт хөрөнгө	2,853,658.7	2,861,722.6	8,063.9
Өр төлбөр	0.0	1,500.0	1,500.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,853,658.7	2,860,222.6	6,563.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,853,658.7	2,861,722.6	8,063.9

Бараа материалын дансны үлдэгдэл хандив, тусламжийн орлогоор 15,472.3 мянган төгрөгөөр, БСШУЯ-аас ирүүлсэн ном, сурах бичиг, хөрөнгөөр 18,204.5 мянган төгрөгөөр өссөн бол бараа материалаас үндсэн хөрөнгө 9,734.5 мянган төгрөгийг шилжүүлж, нийт дүнгээрээ 23,879.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,600.6 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт зориулан 992,896.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 774,670.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 218,225.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гүйцэтгэлээр нийтдээ 986,452.6 мянган төгрөгийг зарцуулсан нь батлагдсан төсөвтэй харьцуулахад 6,443.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдаж, 99.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Ийнхүү төлөвлөсөн зардлаас дутуу зарцуулах болсон шалтгаан нь ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2,900.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,589.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийн дансаар нийтдээ 6,959.3 мянган төгрөгийн орлого хүлээж авсан байна. Үүнд:

1. Айвоару ХХК-аас 100 буудалт даамны тэмцээнд зориулж хандивласан 500.0 мянган төгрөг
2. Түрээсийн сурах бичгийн орлого 2,142.6 мянган төгрөг
3. 1,383.0 мянган төгрөгийн ноолуурын орлого
4. Түүрүүн дэлгэрэх ХХК-аас байрны түрээсийн орлого 1,600.1 мянган төгрөг
5. Спорт заалны түрээсийн орлого 1,333.6 мянган төгрөгийг тус тус хүлээн авч, түрээсийн сурах бичгийн эргэлтийн санд 2,142.6 мянган төгрөг, Байрны түрээсийн орлогоос аймгийн орон нутгийн орлогод 538.0 мянган төгрөгийг орлогоосоо буцаан төвлөрүүлснээр үр дүнгийн тайланд нэмэлт төсвийн орлогыг 4,278.7 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Нэмэлт төсвийн орлогоос 100 буудалт даамны тэмцээнд 500.0, бараа материал худалдаж авах, багш нар туршлага судлах зэрэгт 1,128.0 мянган төгрөг, УБТЗ зам засварын машинт станцад ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн урьдчилгаа болгож 1,500.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч нэр данс зөрүүгийн улмаас буцаж орон орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, энэ дүнгээр авлага, өглөг үүсгэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13, аудитор илрүүлж хэрэгжүүлсэн 3, нийтдээ 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 35433,5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, 17729,3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 17410,0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 294,2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад дараах 17,729.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа. Үүнд:

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 9,734.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аудитын явцад залруулж ангилал зөв болгосон.
2. Төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнаж, төсвийн тохируулга хийгээгүйгээс төгрөгөөр төсөв хэтэрсэн мэтээр тайлагнасан 7,700.8 мянган төгрөгийн алдааг залруулж, төрийн сангийн хуулгатай тохируулсан.
3. Хангамжийн материал дансанд бүртгэлтэй байсан 294.2 мянган төгрөгийн малыг эргэлтийн хөрөнгийн “Мал” дансанд бүртгүүлэв.

Аудитаар дараах 17704,2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 17410,0 төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тус сургууль нь дотуур байрны хүүхдийн хоолны худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй, сургууль дээрээ ажлын хэсэг гаргаж, шалгаруулалтыг хийсэн байв. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1 “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;” заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.” заалт, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13.1. заалтад заасан “төсвийн тухай хуулийн 24.4, 25.10, 44.3-т заасан;” зарлагын гүйлгээ хийхийг хориглох заалтуудыг тус тус зөрчиж, “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад анхаарал татсан дараах асуудал байна. Үүнд:

1. Дорноговь аймаг дахь Иргэний анхан шатны шүүхийн 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 136/ШШ/2018/00104 дугаартай шийдвэрээр сургуулийн захирал О.Одончимэгт ажлаас үндэслэлгүй халагдаж, ажилгүй байсан хугацааны цалин 12,064.4 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 208,3 мянган төгрөг, нийт 12,272.7 мянган төгрөгийг олгуулах шийдвэрийг үндэслэн тус сургуулийн санхүүжилтэд уг мөнгийг нэмж тусгасан тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлэх утга бүхий аймгийн Засаг даргын тамгын газрын 2019 оны 4 сарын 25-ны өдрийн 3/776 тоот албан бичгийг үндэслэн 2019 оны 4 сарын 25-ны өдөр 12,292.7 төгрөгийг шилжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл 1037,8 төгрөгийг Нийгмийн даатгалын санд нөхөн төлсөн.

2. Дорноговь аймаг дахь Иргэний анхан шатны шүүхийн 2019 оны 6 сарын 6-ны өдрийн 136/ШШ/2019/00171 дугаар бүхий шүүхийн шийдвэрийг үндэслэн тус сургуулийн захирал О.Одончимэгийн 2019 оны 9 сарын 16-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Ц.Цэвэлмаад ажлаас үндэслэлгүй халагдсан хугацааны цалин 926,8 төгрөгийг олгож, улсын тэмдэгтийн хураамж 97,0 төгрөгийг төлж, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн байна.

Захиргааны хэргийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 заалтад “ иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар

буцааж төлүүлнэ.”, мөн хуулийн 103.2 заалтад “ Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод хяналтын нэгж хариуцна” гэж заасан байх тул тус сургуулиас албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас гарсан хохирол 14,470.1 мянган төгрөгийг барагдуулах нь Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын газрын хүлээх үүрэг байна гэж үзлээ.

Иймд дараа жилийн аудитаар албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас гарсан хохирол 14,470.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаас нэхэмжилж, төрд учруулсан хохирлыг барагдуулсан эсэхийг авч үзэх нь зүйтэй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үдийн цайны худалдан авах ажиллагаатай холбоотой 21534,9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн ба 2019 онд үдийн цайны худалдан авах ажиллагааг сумын Засаг даргын тамгын газарт хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн байна.

Тус сургуулиас аудитын зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 6 сарын 28-ны өдрийн 80 тоот албан бичгээр Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 17,704.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 10,750.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт Тус сургуулийн дансанд бүртгэлтэй малын үнэ нь зах зээлийн үнээс хэт доогуур үнээр үнэлэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт, 20.2.3 заалтыг тус тус зөрчиж, “Үнэн зөв байх”, “Үнэлгээ” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.
- 3.1.2 Эрсдэл: Зах зээлийн үнээс хэт доогуур үнэлэх нь хөрөнгийг үнэгүйдүүлж, байгууллагад хохирол учруулах эрсдэлтэй.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, малын үнийг зах зээлийн үнэ ханаар бүртгэх талаар зөвлөмж өгөв.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийг зөрчиж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.
- 3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх үр дагавартай.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,081,910.32	142,246,392.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,095,096.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,095,096.00
3121	Төгрөг	00.00	2,095,096.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,095,096.00
33	АВЛАГА	309,762.00	1,500,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	1,500,000.00
335	Бусад авлага	309,762.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	309,762.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	114,772,148.32	138,651,296.05
351	Түүхий эд материал	6,366,713.92	6,652,153.92
35110	Тусгай зориулалттай материал	6,053,764.92	6,053,764.92
35130	Эм боох материал	312,949.00	598,389.00
354	Хангамжийн материал	108,405,434.40	131,704,942.13
35410	Бичиг хэргийн материал	759,840.00	1,193,120.00
35420	Аж ахуйн материал	3,956,723.00	3,703,548.00
35440	Түлш, шатах тослох материал	495,000.00	269,100.00
35450	Барилгын засварын материал	1,079,610.00	2,051,920.00
35460	Хүнсний материал	7,537,087.50	3,053,146.00
35470	Бусад хангамжийн материал	94,577,173.90	121,434,108.13
35600	Мал амьтад	00.00	294,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,738,576,777.50	2,719,476,189.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,738,576,777.50	2,719,476,189.39
392	Биет хөрөнгө	2,693,176,777.50	2,674,076,189.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,461,891,899.49	2,461,891,899.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-55,446,707.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	185,385,291.46	219,714,926.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,466,542.33	-147,588,319.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,871,139.06	131,990,771.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,790,489.05	-49,050,550.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,136,314.88	62,136,314.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	-296,666.38	-3,935,666.23
39217	Ном	42,445,830.37	54,363,519.84
393	Биет бус хөрөнгө	45,400,000.00	45,400,000.00
39301	Програм хангамж	510,000.00	510,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-510,000.00	-510,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,400,000.00	45,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,853,658,687.82	2,861,722,581.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,500,000.00
413	Өглөг	00.00	1,500,000.00
4136	Бусад өглөг	00.00	1,500,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,853,658,687.82	2,860,222,581.44
51	Засгийн газрын хувь оролцоо	2,853,658,687.82	2,860,222,581.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн	528,838,633.66	528,838,633.66

	газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	528,838,633.66	528,838,633.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,774,875,958.68	1,781,439,852.30
51210	Өмнөх үеийн үр дүн	1,774,875,958.68	1,774,875,958.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,563,893.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549,944,095.48	549,944,095.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,853,658,687.82</u>	<u>2,861,722,581.44</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,202,351,300.26	1,081,639,538.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,950,000.26	84,464,708.43
120	Нийтлэг татварын бус орлого	227,950,000.26	84,464,708.43
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	227,950,000.26	84,464,708.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,115,450.00	2,723,676.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	224,834,550.26	81,741,032.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	974,401,300.00	997,174,830.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	966,176,800.00	774,670,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,224,500.00	4,278,630.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,224,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,778,630.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	218,225,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	218,225,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,066,369,396.54	1,074,968,458.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,066,369,396.54	1,074,968,458.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	999,627,411.54	1,034,088,891.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,534,095.00	598,056,713.00
210101	Үндсэн цалин	295,921,714.00	397,240,873.00
210102	Нэмэгдэл	173,799,205.00	139,798,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,683,630.00	15,574,683.00
210104	Урамшуулал	45,129,546.00	45,442,657.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,448,670.00	75,236,969.01
210201	Тэтгэврийн даатгал	43,263,176.00	51,163,898.01
210202	Тэтгэмжийн даатгал	5,313,590.00	5,177,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,250,854.00	5,683,969.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,056,457.00	1,207,692.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,564,593.00	12,004,410.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,809,611.00	212,781,917.00
210301	Гэрэл, цахилгаан	9,011,266.00	9,320,616.00
210302	Түлш, халаалт	193,391,210.00	193,334,900.00
210303	Цэвэр, бохир ус	13,407,135.00	10,126,401.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,028,846.69	7,061,803.00
210401	Бичиг хэрэг	2,021,010.00	1,144,720.00
210402	Тээвэр, шатахуун	749,590.00	1,271,541.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,634,873.00	1,537,262.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,392,500.00	1,650,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,230,873.69	1,457,880.00

2105	Нормативт зардал	24,572,695.00	24,648,927.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	423,610.00	124,560.00
210502	Хоол, хүнс	21,224,825.00	21,890,567.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,924,260.00	2,633,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,645,256.00	2,289,640.00
210604	Урсгал засвар	43,645,256.00	2,289,640.00
2107	Томилолт, зочны зардал	534,600.00	1,850,000.00
210702	Дотоод албан томилолт	534,600.00	1,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,560.00	2,015,622.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,159,560.00	2,015,622.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,894,077.85	110,147,299.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,333,800.00	10,934,261.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,262,500.00	4,875,480.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,297,777.85	94,337,558.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,741,985.00	40,879,566.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,202,342.00	33,807,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,628,600.00	30,866,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,919,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,171,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,482,542.00	2,941,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,539,643.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,539,643.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,218,463.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,218,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,853,703.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,853,703.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	135,981,903.72	6,671,080.17
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	275,306,759.19	107,186.55
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,708,743.71	107,186.55
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	271,598,015.48	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-275,306,759.19	-107,186.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-139,324,855.47	6,563,893.62

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,005,045,750.00</u>	<u>1,001,398,506.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,036,450.00	2,723,676.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,036,450.00	2,723,676.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,036,450.00	2,723,676.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,036,450.00	2,723,676.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,004,009,300.00	998,674,830.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	966,176,800.00	774,670,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	966,176,800.00	774,670,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,832,500.00	5,778,630.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,224,500.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,608,000.00	5,278,630.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	218,225,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	218,225,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>973,775,892.00</u>	<u>972,023,410.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,775,892.00	972,023,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	907,033,907.00	929,643,843.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,542,807.00	598,056,713.00
210101	Үндсэн цалин	295,930,425.00	397,240,873.00
210102	Нэмэгдэл	173,799,205.00	139,798,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,683,630.00	15,574,683.00
210104	Урамшуулал	45,129,547.00	45,442,657.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,624,120.00	74,927,207.01
210201	Тэтгэврийн даатгал	45,482,120.00	50,854,136.01
210202	Тэтгэмжийн даатгал	5,272,258.00	5,177,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,236,642.00	5,683,969.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,057,600.00	1,207,692.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,575,500.00	12,004,410.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,217,701.00	212,478,317.00
210301	Гэрэл, цахилгаан	9,011,266.00	9,320,616.00
210302	Түлш, халаалт	193,799,300.00	193,031,300.00
210303	Цэвэр, бохир ус	13,407,135.00	10,126,401.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,592,663.00	8,957,803.00
210401	Бичиг хэрэг	1,140,000.00	933,600.00
210402	Тээвэр, шатахуун	748,690.00	1,349,241.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,634,873.00	1,537,262.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,392,500.00	1,650,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,676,600.00	3,487,300.00
2105	Нормативт зардал	23,501,320.00	18,610,601.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	470,800.00	410,000.00
210502	Хоол, хүнс	21,533,760.00	17,406,626.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,496,760.00	793,975.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,644,936.00	6,877,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	488,000.00	00.00
210602	Тавилга	00.00	3,720,000.00
210604	Урсгал засвар	43,156,936.00	3,157,100.00
2107	Томилолт, зочны зардал	534,600.00	1,850,000.00
210702	Дотоод албан томилолт	534,600.00	1,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,901,960.00	2,015,622.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,901,960.00	2,015,622.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,473,800.00	5,870,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,333,800.00	345,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,140,000.00	5,525,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,741,985.00	42,379,566.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,202,342.00	33,807,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,628,600.00	30,866,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,919,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,171,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,482,542.00	2,941,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,539,643.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,539,643.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,718,463.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,718,463.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,853,703.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,853,703.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,269,858.00</u>	<u>29,375,096.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,269,858.00	27,280,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,269,858.00	27,280,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,269,858.00	27,280,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,269,858.00	27,280,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-31,269,858.00</u>	<u>-27,280,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,095,096.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,095,096.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,032,534.16	632,000,543.62	1,778,342,923.79	2,893,376,001.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	135,857,890.36	135,857,890.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,032,534.16	632,000,543.62	1,914,200,814.15	3,029,233,891.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	45,806,099.50	00.00	-139,324,855.47	-93,518,755.97
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,838,633.66	549,944,095.48	1,774,875,958.68	2,853,658,687.82
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	528,838,633.66	549,944,095.48	1,774,875,958.68	2,853,658,687.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,838,633.66	549,944,095.48	1,774,875,958.68	2,853,658,687.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,563,893.62	6,563,893.62
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	528,838,633.66	549,944,095.48	1,781,439,852.30	2,860,222,581.44

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	992,896,200.00	986,452,613.01	6,443,586.99	99.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	992,896,200.00	986,452,613.01	6,443,586.99	99.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	960,444,200.00	954,786,213.01	5,657,986.99	99.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,057,600.00	598,056,713.00	887.00	100.00
210101	Үндсэн цалин	390,660,100.00	397,240,873.00	-6,580,773.00	101.68
210102	Нэмэгдэл	139,798,500.00	139,798,500.00	00.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,800,000.00	15,574,683.00	6,225,317.00	71.44
210104	Урамшуулал	45,799,000.00	45,442,657.00	356,343.00	99.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,828,100.00	74,927,207.01	2,900,892.99	96.27
210201	Тэтгэврийн даатгал	51,943,200.00	50,854,136.01	1,089,063.99	97.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,177,000.00	5,177,000.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,471,200.00	5,683,969.00	787,231.00	87.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,294,200.00	1,207,692.00	86,508.00	93.32
210205	Эрүүл мэндийн даатгал	12,942,500.00	12,004,410.00	938,090.00	92.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,068,200.00	212,478,317.00	2,589,883.00	98.80
210301	Гэрэл, цахилгаан	8,493,900.00	9,320,616.00	-826,716.00	109.73
210302	Түлш, халаалт	192,646,300.00	193,031,300.00	-385,000.00	100.20
210303	Цэвэр, бохир ус	13,928,000.00	10,126,401.00	3,801,599.00	72.71
2104	Хангамж, бараа материалын зардал	8,123,400.00	8,076,503.00	46,897.00	99.42
210401	Бичиг хэрэг	933,600.00	933,600.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,350,000.00	1,349,241.00	759.00	99.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,533,800.00	1,537,262.00	-3,462.00	100.23
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	00.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,700,000.00	1,650,400.00	49,600.00	97.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,606,000.00	2,606,000.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	18,614,000.00	18,610,601.00	3,399.00	99.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	410,000.00	410,000.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	17,410,000.00	17,406,626.00	3,374.00	99.98
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	794,000.00	793,975.00	25.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,157,100.00	34,157,100.00	00.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,500,000.00	25,500,000.00	00.00	100.00
210602	Тавилга	5,500,000.00	5,500,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	3,157,100.00	3,157,100.00	00.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,850,000.00	1,850,000.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,850,000.00	1,850,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	1,159,292.00	40,708.00	96.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,159,292.00	40,708.00	96.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5545800.00	5470480.00	75,320.00	98.64

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	345,800.00	345,000.00	800.00	99.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,200,000.00	5,125,480.00	74,520.00	98.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32452000.00	31666400.00	785,600.00	97.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,452,000.00	31,666,400.00	785,600.00	97.58
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,652,000.00	30,866,400.00	785,600.00	97.52
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	00.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00	00.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	992,896,200.00	771,445,776.01	221,450,423.99	77.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	774,670,900.00	770,817,196.01	3,853,703.99	99.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	774,670,900.00	770,817,196.01	3,853,703.99	99.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,225,300.00	215,006,837.00	3,218,463.00	98.53
132001	Орон нутгийн төсвөөс	218,225,300.00	215,006,837.00	3,218,463.00	98.53
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	628,580.00	-628,580.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	628,580.00	-628,580.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	59.00	58.00	01.00	98.31
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	19.00	01.00	95.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,778,630.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,137,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал	881,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	881,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	856,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	856,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,641,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,141,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,141,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,500,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,778,630.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,778,630.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,278,630.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020-02-25			ДГА-2020/1/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн Айраг сумын ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулаагүй	17,410.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	О.Одончимэг Б.Мөнх-Оюун
2	Элэгдлээрээ анхны ертгөө нөхсөн “0” үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	О.Одончимэг Б.Мөнх-Оюун
3	Малыг зах зээлийн хэт доогуур үнээр үнэлж бүртгэсэн	294,2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	О.Одончимэг Б.Мөнх-Оюун